



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 33/

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.4 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон нийт 1,601,559,261.81 (нэг тэрбум зургаан зуун нэг сая таван зуун тавин есөн мянга хоёр зуун жаран нэгэн төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн үнэ бүхий 21 ширхэг барилгыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, тус яамны харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300604

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Нийт өртөг /төгрөгөөр/	Ашиглалтад орсон он, сар, өдөр, актын дугаар	Бүртгэж авах хуулийн этгээдийн нэр, байршил
1	Сургалт мэдээллийн төв /Завхан аймаг, Отгон сум Отгонтэнгэрийн уулын өвөр хэсэг /	166,920,513.93	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Отгон сум
2	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Алдархаан сумын нутагт, Улиастай хотоос зүүн тийш 36 км орчим зайд Улаан хаалганы голын хөндийд/	56,187,202.49	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Алдархаан сум
3	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Идэр сумын нутагт буюу Идэр сумаас зүүн хойш 18 км-т, Ходоод нуураас баруун хойш 4 км-т, Тунын голын хөндийд/	58,287,322.19	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Идэр сум
4	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Идэр сумын нутаг Ногоон нуур гэдэг газарт буюу Идэр сумын төвөөс зүүн ургаш 21 км, Овоот уулын баруун хормойд, Идэрийн голын хөндийд/	55,281,150.85	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Идэр сум
5	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Алдархаан сумын нутаг Богдын гол гэдэг газарт буюу Улиастай хотоос зүүн тийш 50 км, Даян зуслангийн баруун талд/	57,555,280.46	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Алдархаан сум
6	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Идэр сумын нутаг Ямаатын гол буюу Идэр сумын төвөөс зүүн тийш 45 км-т/	54,612,112.71	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Идэр сум
7	Байгаль хамгаалагчийн байр /Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын төвөөс зүүн хойш 14 км-т Мухартын голоос эх авч буй Их Бэрх уулын зүүн хойд бэлд /	57,555,280.46	2019.10.31 № 35/2019	Отгонтэнгэрийн УТХГ-н хамгаалалтын захиргаа, Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум
8	Сургалт мэдээллийн төв /Дотормош Төгөл баг Улаан-уул сум Хөвсгөл аймаг/	244,106,692.09	2019.10.01 № УҚД-2019	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум
9	Байгаль хамгаалагчийн байр /Тэнгис Шишгэд гол, Ринченлхүмбэ сумаас хойд зүгт 61км, Хөвсгөл аймаг/	61,212,667.93	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Ринченлхүмбэ сум
10	Байгаль хамгаалагчийн байр /Хогрог голын эх, Ринченлхүмбэ сумаас хойд зүгт 54км, Хөвсгөл аймаг/	60,858,115.14	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Ринченлхүмбэ сум

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Нийт өртөг /төгрөгөөр/	Ашиглалтад орсон он, сар, өдөр, актын дугаар	Бүртгэж авах хуулийн этгээдийн нэр, байршил
11	Байгаль хамгаалагчийн байр /Өвөлжөөн нуруу Ринченлхүмбэ сумаас зүүн зүгт 21км, Арсайн голын хөндий, Ринченлхүмбэ сумын 4р баг, Хөвсгөл аймаг/	62,662,846.98	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Ринченлхүмбэ сум
12	Байгаль хамгаалагчийн байр /Бэлтэсийн голын зүүн хэсэг, Хүдрэнтийн нурууны зүүн өмнөд хэсэг, Улаан-уул сумаас зүүн өмнөд хэсэгт 23км, Хөвсгөл аймаг/	60,119,947.85	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум
13	Байгаль хамгаалагчийн байр /Жаргалант голын зүүн хэсэг, Баянзүрх сумаас баруун тийш 21 км, Хөвсгөл аймаг/	60,221,663.81	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Баянзүрх сум
14	Байгаль хамгаалагчийн байр /Улаан-уул сумаас зүүн өмнөд хэсэгт 5км, Хөвсгөл аймаг/	60,146,103.38	2019.11.29 № 08	Улаан-тайгын УТХГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум
15	Байгаль хамгаалагчийн байр /Бүтээлийн нуруунаас баруун өмнөд хэсэгт Шавартайн гол, Сэлэнгэ сумын төвөөс баруун хойд зүгт 16.6 км, Булган аймаг/	50,746,317.06	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Булган аймаг, Сэлэнгэ сум
16	Байгаль хамгаалагчийн байр /Дунд Хайлантай голын хөндий, Сэлэнгэбүрэн баг Сэлэнгэ сум, Булган аймаг/	50,838,756.41	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Булган аймаг, Сэлэнгэ сум
17	Байгаль хамгаалагчийн байр /Өвөлжөөн нуруу Ринченлхүмбэ сумаас зүүн зүгт 21км, Арсайн голын хөндий, Ринченлхүмбэ сумын 4р баг, Хөвсгөл аймаг/	52,846,423.65	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймаг, Ринченлхүмбэ сум
18	Байгаль хамгаалагчийн байр /Тарвагтайн гол, Хужирт баг Тэшиг сум Булган аймаг/	55,145,852.60	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Булган аймаг, Тэшиг сум
19	Байгаль хамгаалагчийн байр /Доод нарийн голын бэлчир, Эрин Цаламын арын улаан мод, Тэшиг сумаас хойд зүгт 20 км, Булган аймаг/	55,504,055.10	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Булган аймаг, Тэшиг сум
20	Байгаль хамгаалагчийн байр /Тариатын голын хөндий, Сэлэнгэ сумаас хойд зүгт 14 км, Тариат баг, Сэлэнгэ сум, Булган аймаг/	53,909,476.23	2019.12.31 № 1/84	Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Булган аймаг, Сэлэнгэ сум
21	Сургалт мэдээллийн төв /Булгант тосгон 3-р баг, Ерөө сум, Сэлэнгэ аймаг/	166,841,480.50	2018.12.21 № БУ-11/2019	Хан Хэнтийн ДЦГазрын хамгаалалтын захиргаа, Сэлэнгэ аймаг, Ерөө сум
		1,601,559,261.81		
	НИЙТ ДҮН	(Нэг тэрбум зургаан зуун нэг сая таван зуун тавин есөн мянга хоёр зуун жаран нэгэн төгрөг наян нэгэн мөнгө)		